



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 01293

Улаанбаатар хот

**Баянгол дүүргийн 11 дүгээр  
цэцэрлэгийн эргэлтийн бус хөрөнгийг  
данснаас хасах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 4,556,746.00 /дөрвөн сая таван зуун тавин зургаан мянга долоон зуун дөчин зургаан/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянгол дүүргийн 11 дүгээр цэцэрлэг /Н.Баярцэцэг/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс 1 нэр төрлийн 78,000.00 /далан найман мянган/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгах, 18 нэр төрлийн 4,478,746.00 /дөрвөн сая дөрвөн зуун далан найман мянга долоон зуун дөчин зургаан/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянгол дүүргийн 11 дүгээр цэцэрлэг /Н.Баярцэцэг/-т үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

11570000727

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын  
даргын 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн  
0943 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянгол дүүргийн 11 дүгээр цэцэрлэг

д/д	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоохэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУГ-ын мэргэжилтний дүгнэлт	ЭБХХК-н шийдвэр
1	Цахилгаан пийшин	55	ш	1	112,104.00	112,104.00	112,104.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
2	Аяга ариутгагч	12	ш	1	250,000.00	250,000.00	250,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
3	Тоос сорогч	10	ш	1	169,990.00	169,990.00	169,990.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
4	Зурагт	10	ш	1	85,000.00	85,000.00	85,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
5	Хөгжим	10	ш	1	82,000.00	82,000.00	82,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
6	Принтер	9	ш	1	242,000.00	242,000.00	242,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
7	Зурагт	9	ш	1	80,000.00	80,000.00	80,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
8	Зурагт	9	ш	1	90,000.00	90,000.00	90,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
9	Угаалгын машин	9	ш	1	115,000.00	115,000.00	115,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
10	Таб компьютер	8	ш	1	368,500.00	368,500.00	368,500.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
11	Дээжний хөргөгч	8	ш	1	140,800.00	140,800.00	140,800.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
12	Өнгөт принтер	8	ш	1	380,000.00	380,000.00	380,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
13	Зургийн аппарат	8	ш	1	170,000.00	170,000.00	170,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
14	Зөөврийн компьютер	5	ш	1	1,200,000.00	1,200,000.00	1,200,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
15	Угаалгын машин	8	ш	1	95,000.00	95,000.00	95,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
<b>Тоног төхөөрөмжийн дүн</b>				<b>15</b>		<b>3,580,394.00</b>	<b>3,580,394.00</b>	-				
16	Сэнс	22	ш	1	80,000.00	80,000.00	80,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Татах	Татах
17	Хүүхдийн суултуур	40	ш	2	39,000.00	78,000.00	78,000.00	-	Эвдэрсэн	Актлах	Устгах	Устгах
18	Дрож	19	ш	1	405,900.00	405,900.00	405,900.00	-	Эрүүл ахуйн шаардлага хангахгүй	Актлах	Татах	Татах
19	Дрож	17	ш	1	412,452.00	412,452.00	412,452.00	-		Актлах	Татах	Татах
<b>Тавилга, эд хогшлын дүн</b>				<b>5</b>		<b>976,352.00</b>	<b>976,352.00</b>					
<b>Нийт хөрөнгийн дүн</b>						<b>4,556,746.00</b>	<b>4,556,746.00</b>					
<b>Үүнээс : Татан төвлөрүүлэх хөрөнгө</b>						<b>4,478,746.00</b>	<b>4,478,746.00</b>	-				
<b>Актлах хөрөнгө</b>						<b>78,000.00</b>	<b>78,000.00</b>	-				